

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ХҮҮХДИЙН ЭРХИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Хүүхдийн эрхийн тухай хуульд доор дурдсан агуулгатай зүйл, хэсэг, заалт нэмсүгэй.

1/ 3 дугаар зүйлийн 3.3 дахь хэсэг:

“3.3.Монгол Улсын харьяат хүүхэд хаана оршин сууж байгаагаас үл хамааран төрийн ивээлд байж, зөрчигдсөн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хуулийн дагуу хамгаална.”

2/ 4 дүгээр зүйлийн 4.1.6 дахь заалт:

“4.1.6.хүүхдийн эрхийг хангахад оролцогч бүх талууд үйл ажиллагаандаа мэдээллийн нээлттэй, ил тод байдлыг хангаж ажиллах.”

3/ 10 дугаар зүйлийн 10.1.11 дэх заалт:

“10.1.11.өөртөө болон бусдад давуу байдал тогтоох, ашиг хонжоо олох зорилгоор хүүхдийг эдийн засаг, нийгэм, улс төр, соёлын үйл ажиллагаанд оролцуулахгүй байх;”

4/ 15 дугаар зүйлийн 15.1.9 дэх заалт:

“15.1.9.хүүхдийн эрхийг хангахад бусад төрийн байгууллага, албан тушаалтныг татан оролцуулах, хамтран ажиллах.”

5/ 16 дугаар зүйлийн 16.4.3 дахь заалт:

“16.4.3.Хүүхдийн төлөө үндэсний зөвлөл нь хүүхэд хамгааллын жишиг бодлого, ёс зүйн дүрмийг батлах.”

6/ 18 дугаар зүйлийн 18.1.7, 18.1.8 дахь заалт:

“18.1.7.иргэн, хуулийн этгээд нь хүүхдийн эрхийг хангах, өөрийн явуулж байгаа аливаа үйл ажиллагаа, орчны аюулгүй байдлаа хүүхдэд ээлтэй, хүртээмжтэй байлгах арга хэмжээг авах;”

“18.1.8.байгууллага, аж ахуйн нэгж нь хүүхдийн эрх ашигт сөргөөр нөлөөлөх шийдвэр, үйл ажиллагаандаа хууль тогтоомжид заасан дагуу хариуцлага хүлээх.”

2 дугаар зүйл.Хүүхэд эрхийн тухай хуулийн зарим зүйл заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай.

1/ 8 дугаар зүйлийн 8.1.2 дахь заалт:

“8.1.2.хүүхэд өөрт хамаарах аливаа асуудлаар шийдвэр гаргах, үнэлэлт өгөхөд оролцох, өөрөө болон бусдаар уламжлан хүсэлт гаргах, шийдвэрлүүлэх;”

2/ “20 дугаар зүйл. Хүүхдийн эрхийн хэрэгжилтийг хянах

20.1.Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь төрийн захиргааны болон орон нутгийн байгууллага, тэдгээрийн нийгмийн ажилтан, хүүхдийн эрхийн улсын байцаагчаар дамжуулан хүүхдийн эрхийн хэрэгжилтэд хяналт тавина.

20.2.Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хүүхдийн эрхийн улсын ерөнхий байцаагчийн эрх эдлэх бөгөөд, хүүхдийн эрх, хамгааллын чиглэлээр мэргэшиж, сургалтад хамрагдсан ажилтанд улсын байцаагчийн эрх олгох, цуцлах асуудлыг шийдвэрлэнэ.

20.3.Хүүхдийн эрхийн улсын байцаагч нь хүүхдийн эрх, хамгааллын чиглэлээр мэргэшүүлэх сургалтад хамрагдсан, тухайн чиглэлээр гурваас доошгүй жил ажилласан, боловсрол, нийгмийн шинжлэх ухаан, эрх зүйн чиглэлийн аль нэгээр дээд боловсрол эзэмшсэн байна.

20.4.Хүүхдийн эрхийн улсын байцаагч нь хуулиар олгогдсон чиг үүргийг хэрэгжүүлэх, хүүхдийн эсрэг зөрчлийг шалган шийдвэрлэх замаар хууль тогтоомжийн биелэлтийг хангуулна.

20.5.Хүүхдийн эрхийн улсын байцаагч бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ дараах баримт бичиг үйлдэнэ:

20.5.1.хууль тогтоомж, нийтээр дагаж мөрдөх эрх зүйн акт зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, хууль тогтоомжийг хэрхэн мөрдөж ажиллах арга, хэлбэрийн талаар зөвлөмж үйлдэнэ;

20.5.2.хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг таслан зогсоох, залруулах, түүний шалтгаан нөхцөлийг арилгах талаар хугацаатай албан шаардлага үйлдэнэ;

20.5.3.холбогдох зөвшөөрлийг хүчингүй болгуулах талаар эрх бүхий этгээдэд санал хүргүүлэх, хүүхэд хамгааллын үйлчилгээ нь хууль тогтоомж, нийтээр

дагаж мөрдөх эрх зүйн актын шаардлагыг хангаж байгаа эсэхийг тодорхойлох, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шинжээчээр оролцохдоо дүгнэлт үйлдэнэ.

20.6.Хүүхдийн эрхийн улсын байцаагч нь хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнээс баталсан албаны болон хувийн дугаар бүхий үнэмлэх, тэмдэг, хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

20.7.Хүүхдийн эрхийн улсын байцаагчийн орон тоог тухайн орон нутгийн хүн амын тоо, эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд, хүүхдийн эрхийн эсрэг гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдлыг харгалзан 3 жил тутамд Засгийн газраас тогтооно.

20.8.Хүүхдийн эрхийн улсын байцаагчийн ажиллах дүрмийг Засгийн газар батална.

3 дугаар зүйл. Хүүхдийн эрхийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.11 дэх заалтын дугаарлалтыг “10.1.12” гэж, 15 дугаар зүйлийн 15.1.9 дэх заалтын дугаарлалтыг “15.1.10” гэж тус тус өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл. Энэ хуулийг Хүүхэд хамгааллын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын...өдөр

Улаанбаатар
хот

ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛТЭЙ ТЭМЦЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд доор дурдсан агуулгатай зүйл, заалт, хэсэг нэмсүгэй:

20 дугаар зүйлийн 20.4 дэх заалт:

“20.4. хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны болон орон нутгийн байгууллага нь Хамтарсан баг хүүхэд, түүний гэр бүлд хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэхэд нь мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллана.”

2 дугаар зүйл. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн дараахь зүйл, заалт, хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/ 12 дугаар зүйлийн 12.2.4 дэх заалт:

“12.2.4.Хамтарсан багийн үйл ажиллагаанд мэргэжлийн туслалцаа, дэмжлэг үзүүлэх.”

2/ 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэг:

“20.1.Хамтарсан багийг сум, аймгийн төвийн баг, хороонд байгуулна. Хамтарсан баг нь сум, өрхийн эрүүл мэндийн төвийн эмч, сум, хороо, сургуулийн, халамжийн, хүүхэд, гэр бүлийн хөгжлийн нийгмийн ажилтан, цагдаагийн алба хаагч, хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлдэг төрийн бус байгууллагын төлөөллөөс бүрдэх бөгөөд хамтарсан багийг тухайн сум, аймгийн төвийн сумын баг, хорооны Засаг дарга ахална.”

3 дугаар зүйл. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3 дахь хэсгийн “эрүүл мэндийн асуудал эрхэлсэн” гэснийг “санхүү, төсвийн асуудал эрхэлсэн” гэж өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл. Энэ хуулийг Хүүхэд хамгааллын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын...өдөр

Улаанбаатар
хот

ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд доор дурдсан агуулга бүхий хэсэг, заалт нэмсүгэй.

1/10 дугаар зүйлийн 10.2.8 дахь заалт:

“10.2.8.гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх арга хэмжээг хүүхдийн нас, сэтгэхүйн онцлогт тохируулан зохион байгуулах.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг Хүүхэд хамгааллын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын...өдөр

Улаанбаатар
хот

ХҮН ХУДАЛДААЛАХТАЙ ТЭМЦЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуульд дараах агуулга бүхий хэсэг, заалт нэмсүгэй:

1/ 5 дугаар зүйлийн 13, 14 дэх хэсэг:

“5.13.Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч хүүхэдтэй ажилладаг мэргэжилтэн, нийгмийн ажилтныг мэргэшүүлэх, давтан сургах сургалтыг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага зохион байгуулна.

5.14.Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч хүүхэдтэй ажилладаг төрийн бус байгууллагын үйл ажиллагааг дэмжих, энэ хуулийн 5.13-т заасан заасан чиг үүргийг гүйцэтгэхдээ тухайн чиглэлээр мэргэшсэн төрийн бус байгууллагатай хамтран ажиллаж болно.”

2/ 9 дүгээр зүйлийн 9.6 дахь хэсэг:

“9.6.Бэлгийн мөлжлөг, хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч хүүхдийн аюулгүй байдлыг хангах түр хамгаалах байрны стандартыг стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага батална.”

3/ 13 дугаар зүйлийн 13.5 дахь хэсэг:

“13.5.Бэлгийн мөлжлөг, хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч хүүхдэд урт хугацааны хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэх журмыг хууль зүйн болон хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.”

2 дугаар зүйл. Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.11 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай.

“5.11.Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь бэлгийн мөлжлөг, хүн худалдаалах гэмт хэрэгт өртөх эрсдэлтэй хүүхдэд хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлнэ.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Хүүхэд хамгааллын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын...өдөр

Улаанбаатар
хот

НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Нийгмийн халамжийн тухай хуульд доор дурдсан агуулгатай хэсэг нэмсүгэй.

1/ 19 дүгээр зүйлийн 19.11 дэх хэсэг:

“19.11.эрсдэлтт нөхцөлд байгаа, Гэр бүлийн тухай хуулийн 25.5-д заасан хүүхдэд үзүүлэх төрөлжсөн асрамжийн үйлчилгээг төрийн болон төрийн бус байгууллага, иргэн үзүүлнэ”

2/ 19 дүгээр зүйлийн 19.12 дахь хэсэг

“19.12.Иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллага нь энэ зүйлийн 19.2-т заасан иргэнд асрамжийн үйлчилгээ үзүүлэх тохиолдолд нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай байгуулсан гэрээний үндсэн дээр үзүүлэх нэг асруулагчид үзүүлэх хувьсах болон үйлчилгээний зардлыг нийгмийн халамжийн сангаас санхүүжүүлнэ.”

2 дугаар зүйл. Нийгмийн халамжийн тухай хуулийн зарим хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай.

1/ 19 дүгээр зүйлийн 19.4 дэх хэсэг:

“19.4.Энэ хуулийн 19.2.1, 19.2.2, 19.2.4-т заасан иргэн болон 19.2.3-т заасан байнгын асрамжид байдаг хөгжлийн бэрхшээлтэй 18 хүртэлх насны хүүхдийг аймаг, дүүргийг нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллагын, энэ хуулийн 19.2.3-т заасан эрсдэлт нөхцөлд байгаа, Гэр бүлийн тухай хуулийн 25.5-д заасан хүүхдийг аймаг, дүүргийн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн байгууллага, нийгмийн ажилтны саналыг тус тус үндэслэн төрөлжсөн асрамжийн үйлчилгээнд хамруулах тухай шийдвэрийг аймаг, дүүргийн Засаг дарга гаргана.

2/ 19 дүгээр зүйлийн 19.7 дахь хэсэг.

“19.7.Энэ хуулийн 19.2, 19.11-д заасан үйлчилгээнд хүүхэд, иргэнийг хамруулах, шилжүүлэх, гаргах болон асрамжийн байгууллагын санхүүжилт, хөрөнгийн зарцуулалт, үйл ажиллагаанд хяналт тавих журмыг нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

3 дугаар зүйл. Нийгмийн халамжийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.9 дэх заалтын “Хүнд нөхцөлд” гэснийг “Эрсдэлт нөхцөлд” гэж, 19 дүгээр зүйлийн 19.1.3 дахь заалтын “Хүнд нөхцөлд” гэснийг “Эрсдэлт нөхцөлд” гэж, 19 дүгээр зүйлийн 19.2.3 дахь заалтын “Хүнд нөхцөлд” гэснийг “Эрсдэлт нөхцөлд” гэж тус тус өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл. Энэ хуулийг Хүүхэд хамгааллын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын...өдөр

Улаанбаатар
хот

ГЭР БҮЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Гэр бүлийн тухай хуулийн зарим зүйл, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай.

“25.8.Сум, дүүргийн Засаг дарга энэ хуулийн 25.4, 25.5-д заасан хүүхдийн тухай мэдээллийг хүлээн авч хүүхдийг гэр бүлийн орчинд хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэх, хүүхдийг төрөл, садан, ойр дотны болон асралт гэр бүлд байлгаж үйлчилгээ үзүүлэх асуудлыг Хүүхэд хамгааллын тухай хуульд заасны дагуу шийдвэрлэнэ.

“25.10.Хүүхэд энэ хуулийн 25.8-д заасны дагуу хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх боломжгүй бол аймаг, дүүргийн Засаг дарга хүүхдийг төрөлжсөн асрамжийн үйлчилгээнд хамруулж үйлчилгээ үзүүлэх асуудлыг Хүүхэд хамгааллын тухай хууль, Нийгмийн халамжийн тухай хуульд заасны дагуу шийдвэрлэнэ.

2 дугаар зүйл. Гэр бүлийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн гарчигийн “Хүнд нөхцөлд” гэснийг “Эрсдэлт нөхцөлд” гэж, 56 дугаар зүйлийн 56.1 дэх хэсгийн “хүнд нөхцөлд” гэснийг “эрсдэлт нөхцөлд” гэж, 56 дугаар зүйлийн 56.2 дахь хэсгийн “хүнд нөхцөлд” гэснийг “эрсдэлт нөхцөлд” гэж тус тус өөрчилсүгэй.

3 дугаар зүйл. Гэр бүлийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.7, 25.9 дэх хэсэг, 74, 75 дугаар зүйлийг тус тус хүчингүй болгосугай.

4 дүгээр зүйл. Энэ хуулийг Хүүхэд хамгааллын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын....өдөр

Улаанбаатар
хот

ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.2016 оны 02 дугаар сарын 05-ны өдөр батлагдсан Хүүхэд хамгааллын тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Хүүхэд хамгааллын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг